



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 147,000,000.00 (нэг зуун дөчин долоон сая) төгрөгийн балансын үнэ, 74,725,000.00 (далан дөрвөн сая долоон зуун хорин таван мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ланд круйзер-200 маркийн, 33-99 БРА улсын дугаартай, JTMNU01J004131016 арлын дугаартай автомашиныг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бүрэн эрхт төлөөлөгч Т.Батдондог, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Х.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ